



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/0ч

Бор-Өндөр

Байгууллагын үнэлгээний багийг шинэчлэн
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 301 дугаартай “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэх чиг үүрэг бүхий үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний багийн ахлагч:

Б.Оюунтуяа

Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Ц.Жаргалсайхан

Хууль, эрх зүй дотоод ажил хариуцсан
мэргэжилтэн


Ажлын хэсгийн гишүүд:

Б.Цогзолмаа

Холбоо 2 дугаар багийн Зохион байгуулагч

2. Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг хууль, дүрэм журмын дагуу үнэлж жил бүрийн эхний хагас жилийн 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор, мөн сүүлийн хагас жилийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор баталгаажуулан тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА



3.УУГАНЖАРГАЛ